



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Халзан дулаан ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/14/НА-СТА-ОНӨ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт 2023 он</p>	<p>Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123 Цахим хаяг: davaag@audit.gov.mn</p> <p>Аудитор: Б.Мөнхбамбар Утас: 70512127 Цахим хаяг: munkhbambarb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
4. АУДИТЫН ТАЙЛАН	10
4.1 Ерөнхий зүйл	10
4.2 Материаллаг байдал.....	11
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	11
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	11
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
4.5.1 Завсрын аудитын талаар	12
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
5.1 Төлбөрийн акт	12
5.2 Албан шаардлага	12
5.3 Зөвлөмж.....	13
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	14

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР ХАЛЗАН ДУЛААН
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
О.БАЯРСАЙХАН ТАНАА

2023.03.22 № 152
танай _____ - ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Халзан дулаан ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Халзан дулаан ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Халзан дулаан ОНӨААТҮГ нь 2022 онд нийт 13-н орон тоотой үйл ажиллагааг хэвийн явуулсан бөгөөд цалингийн зардалд 98,890.3 мянган төгрөг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Гүйцэтгэлээр 232,937.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 226,101.2 мянган төгрөгийн зардал гарган, 6,836.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Халзан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/04 дугаар тогтоолоор "Сүхбаатар аймгийн Халзан дулаан" ОНӨААТҮГ-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан боловч гүйцэтгэл, үр дүнг нь дүгнээгүй байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	9,892,580.20	19,295,667.67
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,704,845.70	2,527,267.67
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	4,704,845.70	2,527,267.67
31210	Төгрөг	4,704,845.70	2,527,267.67
31213	Арилжааны банк дахь харилцах	4,704,845.70	2,527,267.67
33	АВЛАГА	2,987,178.00	15,950,000.00
33401	Дансны авлага /ТӨҮГ/	2,987,178.00	15,950,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,200,556.50	818,400.00
35400	Хангамжийн материал	2,200,556.50	818,400.00
35440	Түлш, шатах тослох материал	2,200,556.50	818,400.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	407,449,549.54	353,671,731.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	407,449,549.54	353,671,731.64
39200	Биет хөрөнгө	404,548,712.98	350,874,131.64
39201	Барилга, байгууламж, орон сууц	411,136,047.45	411,136,047.45
39202	Хуримтлагдсан элэгдэл	-40,991,072.80	-72,824,724.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	3,000,000.00	3,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,400,000.00	-3,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	43,524,900.00	38,217,500.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,769,880.67	-32,597,291.67
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,724,000.00	2,022,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,044,780.00	-404,400.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	18,000,000.00	18,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,630,501.00	-12,675,000.00
39300	Биет бус хөрөнгө	2,900,836.56	2,797,600.00
39301	Програм хангамж	990,000.00	990,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-886,763.44	-990,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,797,600.00	2,797,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	417,342,129.74	372,967,399.31
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	87,195,103.84	71,406,303.75
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	87,195,103.84	71,406,303.75
41300	Өглөг	6,885,773.04	100,790.13
41360	Бусад өглөг	6,885,773.04	100,790.13
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	6,885,773.04	100,790.13
41400	Урьдчилж орсон орлого	80,309,330.80	71,305,513.62
41440	Бусад урьдчилж орсон орлого	80,309,330.80	71,305,513.62
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	330,147,025.90	301,561,095.56
51	Засгийн газрын хувь оролцоо	330,147,025.90	301,561,095.56
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	300,094,600.00	300,094,600.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-43,738,621.09	-72,324,551.43
51210	Өмнөх үеийн үр дүн	-49,667,802.58	-79,160,844.18
51220	Тайлант үеийн үр дүн	5,929,181.49	6,836,292.75
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	73,791,046.99	73,791,046.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	417,342,129.74	372,967,399.31

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	198,549,814.06	232,937,519.32
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	198,549,814.06	232,937,519.32
120	Нийтлэг татварын бус орлого	198,549,814.06	232,937,519.32
120010	Борлуулалтын орлого (Цэвэр) /ТӨҮГ/	198,549,814.06	243,793,156.02
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	0.00	10,855,636.70
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	192,620,632.57	226,101,226.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	192,620,632.57	226,101,226.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	192,620,632.57	226,101,226.57
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	176,894,480.21	231,929,617.93
210811	Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/	176,894,480.21	231,929,617.93
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,726,152.36	-5,828,391.36
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,726,152.36	-5,828,391.36
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	5,929,181.49	6,836,292.75
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	5,929,181.49	6,836,292.75

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	286,752,600.00	73,791,046.99	-49,667,802.58	310,875,844.41
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	286,752,600.00	73,791,046.99	-49,667,802.58	310,875,844.41
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	13,342,000.00	0.00	0.00	13,342,000.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	5,929,181.49	5,929,181.49
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	300,094,600.00	73,791,046.99	-43,738,621.09	330,147,025.90
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	300,094,600.00	73,791,046.99	-43,738,621.09	330,147,025.90
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-35,422,223.09	-35,422,223.09
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	300,094,600.00	73,791,046.99	-79,160,844.18	294,724,802.81
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	6,836,292.75	6,836,292.75
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	300,094,600.00	73,791,046.99	-72,324,551.43	301,561,095.56

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	220,620,665.06	262,779,278.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	220,620,665.06	262,779,278.99
120	Нийтлэг татварын бус орлого	220,620,665.06	262,779,278.99
120009	Бусад орлого	0.00	31,900,000.00
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	220,620,665.06	230,879,278.99

II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	203,518,410.05	261,519,357.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	203,518,410.05	261,519,357.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	203,518,410.05	261,519,357.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,507,870.00	76,483,929.00
210106	Ажилагчдад төлсөн /ТӨҮГ/	59,507,870.00	76,483,929.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,318,873.86	22,406,381.46
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	19,318,873.86	22,406,381.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,353,714.57	6,828,344.84
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	5,353,714.57	6,828,344.84
2104	Хангамж, бараа материалын зардал	97,508,376.00	131,809,795.72
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө /ТӨҮГ/	48,561,955.00	42,082,218.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	48,946,421.00	89,727,577.72
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,829,575.62	23,990,906.00
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	21,738,635.62	23,956,206.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	90,940.00	34,700.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	17,102,255.01	1,259,921.97
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	13,342,000.00	3,437,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,342,000.00	3,437,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,342,000.00	3,437,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,342,000.00	3,437,500.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-13,342,000.00	-3,437,500.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,760,255.01	-2,177,578.03
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	944,590.69	4,704,845.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,704,845.70	2,527,267.67

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	х.нэгж	2021 оны гүйцэтгэл	2022 оны	
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт				
	а/Гол нэр төрлөөр	Биет			
	б/Үнийн дүнгээр	мян.төг			
2	Нийт орлого	мян төг	198,549.8	211,786.1	232,937.5
	А. Халаалтын орлого	мян твг	188,409.8	191,786.1	211,893.2
	Б. Үйл ажиллагааны бус орлого	мян төг	10,050.0	20,000.0	31,900.0
3	Нийт зардал	мян төг	192,620.6	191,019.6	231,929.6
	Үүнээс: Удирдлагын зардал	мян төг	133,112.7	133,820.2	129,964.7
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян төг	5,929.2	20,765.5	1,007.9
5	Цэвэр ашиг /алдагдал/	мян төг	(43,738.6)	(43,738.6)	(72,324.5)
6	Төсвийн төлбөрт нийт дүн	мян төг			

	а/Орлогын татварт	мян төг	3,324.9	506.5	
	б/НӨТ	мян.төг	13,624.4	17,044.5	15,918.9
	в/НДШ	мян.төг	19,318.9	22,406.4	15,346.5
	г/Хүн амын орлогын татвар	мян төг	4,789.3	2,720.5	4,951.4
	д/Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян төг			
	е/Гаалийн татвар	мян төг			
	ё/Тээврийн хэрэгслийн татвар	мян төг			
	ж/Бусад татвар	мян төг			
7	Төрийн өмчийн ногдол ашиг	мян төг			
8	Нийт ажиллагсдын тоо	хүн	13.0	13.0	13.0
9	Нийт цалингийн сан	мян төг	59,507.9	76,483.9	61,385.8
10	Нэг ажилтны дундаж цалин	мян төг	509.9	509.9	564.9
11	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төг			
1?	Хөрөнгө оруулалт	мян төг		82,000.0	
13	Нийт авлага	мян төг	2,987.2		15,950.0
	Үүнээс Найдваргүй	мян төг			
14	Нийт өглөг	мян төг	6,885.9		100.7
	Богино хугацаат өр төлбөр	мян төг			
	Урт хугацаат өр төлбөр	мян төг			

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Халзан дулаан ОНӨААТҮГ-ын зорилго нь аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг дулаанаар хангахтай холбогдож үүссэн харилцааг зохицуулах, түүнд тавигдах шаардлага, үйлчилгээний түвшин, чанар, төлбөр тооцооны нөхцөл болон хэрэглэгчийн эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлох зорилготой, хамтын үйл ажиллагааг сайжруулан хэрэглэгчдийн эрх ашгийг хүндэтгэн дээдлэн хамгаалахад оршино.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 292 дугаар тогтоолоор баталсан “Аж ахуйн харилцааны дүрэм”-д тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг тусгай зөвшөөрөл эзэмшигч-хэрэглэгч хоорондын аж ахуйн харилцааны дүрмийн зорилго нь Эрчим хүчний тухай хуульд заасан дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хэрэглэгчийг дулаанаар хангахтай холбогдож үүссэн гэрээний нөхцөл, түүнд тавигдах шаардлага, үйлчилгээний түвшин, чанарын үзүүлэлт, төлбөр тооцооны нөхцөлийг тусгасан хэм хэмжээг тодорхойлоход оршино” гэж тодорхойлсон байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд ОНӨААТҮГ статустай байна. Өмчийг 100 хувь төр эзэмшиж байна.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Сүхбаатар аймгийн Халзан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/07 дугаартай тогтоолыг үндэслэн Халзан дулаан ОНӨААТҮГ-ыг байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлд “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй: ... 5/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих;...” гэсэн заалттай нийцэж байна.

Сүхбаатар аймгийн Халзан сумын Засаг даргын 2016 оны 01 дүгээр сарын 04-ны өдрийн Б/01 дугаартай тушаалаар захирлыг томилсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халзан дулаан ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Халзан дулаан ОНӨААТҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Халзан дулаан ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн бөгөөд өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 912,068.8 мянган төгрөгөөр буюу 12.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,704.8	2,527.3	-2,177.5
Авлага	2,987.2	15,950.0	12,962.8
Бараа материал	2,200.5	818.4	-1,382.1
Үндсэн хөрөнгө	407,449.6	353,671.7	-53,777.9
Нийт хөрөнгө	417,342.1	372,967.4	-44,374.7
Өр төлбөр	87,195.1	71,406.3	-15,788.8
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	330,147.0	301,561.1	-28,585.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	417,342.1	372,967.4	-44,374.7

Харилцах дансны үлдэгдэл 2,527.3 мянган төгрөг болж 2,177.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Авлагын үлдэгдэлд 15,950.0 мянган төгрөг болж 12,962.8 мянган төгрөгөөр өссөн нь НР85Ж зуух худалдан авах гэрээг Одкон угсралт ХХК-тай байгуулж, гэрээний урьдчилгаа төлбөр 15,950.0 мянган төгрөг шилжүүлсэн нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд: Өөрийн хөрөнгөөр 3,437.5 мянга төгрөгийн хөрөнгө худалдан авч, Орон нутгийн өмчийн газрын 2022 оны 530 тоот шийдвэрээр 11,446.9 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан бөгөөд хөрөнгийн элэгдлийн зардлаар буурсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 87,195.1 мянган төгрөгийн өр төлбөр байна. Өр төлбөрийн хэмжээ өмнөх оноос 15,889.6 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онуудад үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг урьдчилж орсон орлогоор бүртгэсэн бөгөөд тус хөрөнгө элэгдлийн зардлаараа буурсан нь нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Халзан дулаан ОНӨААТҮГ нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Халзан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/04 дугаар тогтоолоор “Сүхбаатар аймгийн Халзан дулаан” ОНӨААТҮГ-ийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 211,786.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 255,524.7 мянган төгрөгөөр, 43,738.6 мянган төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 232,937.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 226,101.2 мянган төгрөгийн зардал гарган, 6,836.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 211,786.1 мянган төгрөг болж төлөвлөснөөс 232,937.5 мянган төгрөг буюу 10 хувиар давсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 191,019.6 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 35,081.7 мянган төгрөг буюу 18 хувиар илүү гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд цэвэр ашиг 6,836.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 13,682.2 мянган төгрөгөөр бууралттай гарсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халзан дулаан ОНӨААТҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад өр төлбөр, түлш халаалтын зардалтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Мөнхбамбар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Халзан дулаан ОНӨААТҮГ нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 1/02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 247,812.5 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 4,956.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,469.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1¹-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд уг зардлууд 153.1 мянган төгрөгөөр өссөн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллийг бүрэн оруулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

¹ байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;

тогтоомжийн холбогдох заалттай болон бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Халзан дулаан ОНӨААТҮГ-т завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,053.1	1	1,053.1	100
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	2	1,090.0	2	1,090.0	100
Нийт дүн	3	2,143.1	3	2,143.1	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 18,418.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 2,468.6 мянган төгрөгийн зөрчилд² 1 төлбөрийн акт тогтоож, 15,950.0 мянган төгрөгийн зөрчлийн арилгах 1 албан шаардлага хүргүүлж, алдааг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Өмнөх оны санхүүгийн тайланд өр төлбөр үүсгээгүй байхад 2,468.6 мянган төгрөгийн нүүрсний үнэ, нүүрс тээврийн хөлсийг тайлант онд барагдуулсан зөрчил илэрлээ. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно/, 13.6 /Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна./ 20 дугаар зүйлийн 20.1.4 /хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулах ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;/, 20.2.5 /дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;/ заалтыг тус тус зөрчсөнд төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

Халаалтын НР85Ж маркийн тогоог 31,900.0 мянган төгрөгөөр худалдан авсан бөгөөд худалдан авах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, шууд гэрээ байгуулсан байна

Энэ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 /харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар;/, 33 дугаар зүйлийн 3.2.1 дахь /үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх;/, 19 дүгээр зүйлийн 1 дэх /Захиалагч тендерийн баримт бичгийг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам, аргачлалын дагуу бэлтгэнэ./ заалтуудыг тус тус зөрчсөнд албан шаардлага хүргүүлэв.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.3 Зөвлөмж

1. Үйл ажиллагаатай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулаагүй байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 /Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн гүйцэтгэх захирал, бусад албан хаагчид олгох цалин хөлсний нийтлэг жишгийг төрийн өмчит хуулийн этгээдийн хувьд Засгийн газар, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хувьд тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно./ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4 /үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох;/ дахь заалтыг зөрчсөн.

Өгсөн зөвлөмж:

Үйл ажиллагааны чиглэл, ашигт ажиллагааны түвшнийг харгалзан цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулах

2. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар хүртээмжид дотоод хяналтыг хэрэгжүүлсэн боловч өмч хөрөнгө, төсвийн санхүүгийн зарцуулалтад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Дээд шатны байгууллага болон эрх бүхий этгээд дотоод хяналтын журмыг батлаагүй бол Засгийн газрын 2011 оны “Нийтлэг журам батлах тухай” 311 дүгээр тушаалын дагуу байгууллагын дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөх журмыг баталж, өмч хөрөнгө, хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналтыг хэрэгжүүлэх

3. Балансын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын тайланг гаргахдаа анхан шатны баримтыг нярав бүгдийг бичиж зарлага болгосон зөрчил илэрлээ. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

Бараа материалын тайланг гаргахдаа материал үнэ бүхий зүйлийг байгууллагын дотоод хэрэгцээнд зарцуулах шаардлага гарсан үед уг зүйлийг авч зарцуулах хүн шаардах хуудсыг бичиж зөвшөөрөл авах, анхан шатны баримтын иж бүрдлийг хангах, түүнд тавих хяналтыг сайжруулж, тооцоог хийж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/												
Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анхан шатны барим хуурамчаар бүрдүүлсэн	1	2,468.6	1	2,468.6	-	-	-	-	-	-	-	-
Тендер сонгон шалгаруулалт зарлаагүй	1	31,900.0	-	-	1	31,900.0	-	-	-	-	-	-
Цалин хөлсний нийтлэг жишгийг батлуулаагүй байна	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дотоод хяналтын хэрэгжүүлээгүй	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Анхан шатны баримтын бүрдлийг хангах	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	5	34,368.6	1	2,468.6	1	31,900.0	3	-	-	-	-	-